

-Тодорхойлолтын дугаар автоматаар үүсэх ба бааз болон хадгалагдана.

-QR кодоор баталгаажих тул-Тамга, гарын үсэг шаардлагагүй

-<http://portal.ecustoms.mn> Хаягаар тодорхойлолтоо шалгаж болно.

**Албан бичгээр тодорхойлолт авах хэлбэр:**

Гаалийн байгууллагын мэдээллийн санд бүртгэлтэй, татварын тооцоотой/өр, авлагатай/ аж ахуйн нэгж, иргэн, хуулийн этгээд албан бичгээр Гаалийн ерөнхий газрын татвар орлогын газарт хандаж тодорхойлолтыг ажлын 3 хоногт багтаан авах боломжтой.

**Үүнд шаардлагатай бичиг баримт:**

1. Иргэн, аж ахуйн нэгжийн албан хүсэлт;
2. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар;
3. Иргэний үнэмлэхний хуулбар.



Танд лавлах зүйл байна уу!



**1800-1281**

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулт



Санал

## ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:  
Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",  
Улаанбаатар-14193, Монгол Улс  
Утас: (976-11) - 350049  
Факс: (976-11) - 350048  
E-mail: info@customs.mn  
Интернет: <http://www.customs.gov.mn>



МОНГОЛ УЛСЫН  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

## ЦАХИМ ТОДОРХОЙЛОЛТЫН ГАРЫН АВЛАГА



УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН

## ГААЛИЙН БАЙГУУЛЛАГАД ӨРТЭЙ ЭСЭХ ТОДОРХОЙЛОЛТ

The screenshot shows the Mongolian Customs General Administration website. At the top, there is a navigation bar with links for 'Mongolian Customs General Administration', 'MCGA | Information | Statistics | Customs Law | Community | Search'. Below this, there is a search bar with 'AI' selected and a 'Search' button. To the left, there is a login section with 'ID' and 'PW' fields and a 'Login' button. Below the search bar, there are several news articles. One article is titled 'Мөнгө угаах зорилго ердөө л ганц бөгөөд хялбар аргаар баяжих, ашиг орлого оло' with a date of 20090610. Another article is titled 'Хөгжлийн эдийн засаг' with a date of 20090610. There are also buttons for 'Лавлагаа шалгах', 'Тодорхойлолт авах', and 'Тодорхойлолт шалгах'. At the bottom, there is a footer with the text 'Монголын ГААЛЬ. Гаалийн Ерөнхий Газар. Бүх эрх хуулиар хамгаалагдсан. © 2018 он. E-Customs requires Internet Explorer 5.5 or higher. Best viewed with resolution more as 1024x768'.

*ГЕГ-ын даргын 2018-07-06 А/133 дугаар тушаалаар батлагдсан “Статистик мэдээлэл, лавлагаа болон гаалийн байгууллагад өртэй эсэх тодорхойлолт авах тухай хүсэлтийг шийдвэрлэх журам”*

2.1.3 “Гаалийн байгууллагад өртэй эсэх тодорхойлолт гэж иргэн, хуулийн этгээдийн гаалийн байгууллагатай татварын өр, авлагын тооцоотой эсэх талаарх мэдээллийг хэлнэ.

Гаалийн байгууллагад өртэй эсэх тодорхойлолтын хэлбэр нь:

- Цахимаар;
- Албан бичгээр;

**-Цахимаар тодорхойлолт авах хэлбэр:**

**Алхам 1:** Системд нэвтрэн орох: Иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага <http://portal.ecustoms.mn> хаягаар системд нэвтрэн цахим тодорхойлолт авах боломжтой.

**Алхам 2:** Цонх сонгох: Зүүн гар талаас “Тодорхойлолт авах” цонхыг сонгоно.

**Алхам 3:** Мэдээлэл оруулах: Цонх бүрт холбогдох мэдээллийг оруулж баталгаажуулах товч дарна.

The screenshot shows a registration form with the following fields: 'Регистрийн №:' (Registration No.), 'Нэр:' (Name), 'Төрөл:' (Type) with a dropdown menu set to 'Бүгд' (All), 'Эхлэх огноо:' (Start Date) set to '2017-12-03', and 'Дуусах огноо:' (End Date) set to '2018-12-03'. There is a checkbox for 'I'm not a robot' and a reCAPTCHA logo. At the bottom, there is a large button labeled 'Баталгаажуулах' (Confirm).

**Алхам 4:** Хэвлэх: Тодорхойлолт хэвлэхэд бэлэн болж PDF-ээр харагдана.

The screenshot shows a receipt form from the Mongolian Customs. At the top, there is the Mongolian Customs logo and the text 'МОНГОЛЫН ГААЛЬ'. Below this, there is a section titled 'Тодорхойлолт' (Receipt). The form contains the following information: 'АНН, Иргэн:' (Name, Citizen), 'Регистр №:' (Registration No.) 10227794, 'Тодорхойлолтод хангах огноо:' (Valid until) 2016.01.01 - 2018.12.03, 'Бүрдүүлж хийсэн эсэх:' (Completed) Үгүй, 'Тайлбар:' (Remarks) Улсын бүртгэлийн 10227794 тоот регистрийн дугаартай "Татвар төлөгчид туслах итгэлт тухай төв НҮТБ" нь дээрх хугацаанд гаалийн нөдүүлгээр бүрдүүлэлт хийсэн нэдэлэл гаалийн нөдүүлгийн санд бүртгэгдэхгүй тул татварын өргүй боломжыг тодорхойлсон., 'Тодорхойлолт гаргасан огноо:' (Issued on) 2018-12-03. At the bottom, there is a QR code and the text 'Тодорхойлолтын дугаар: T188PHQE4' and the URL 'http://portal.ecustoms.mn/CEPS/checkT.jsp хаягаар тодорхойлолтоо шалгана уу.'